



ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

᠒᠐᠒᠒ оны ᠐1 сарын 1᠐ өдөр

Дугаар ᠔113

Улаанбаатар хот

Б.Өнөржаргалд буцалтгүй тусламж олгох тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.8 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Гаалийн тухай хуулийн 271¹ дүгээр зүйлийн 271¹.1.7 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн албан хаагчид нөхөх төлбөр олгох журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.2.7 дахь заалт, Гаалийн ерөнхий газрын даргын 2021 оны А/124 дүгээр тушаалаар батлагдсан "Гаалийн байгууллагын хөдөлмөрийн дотоод журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.1.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гаалийн ерөнхий газрын Гаалийн хяналт, шалгалтын газрын гаалийн улсын байцаагч Бат-Өлзийгийн Өнөржаргалын төрсөн эцэг нь нас барсан тул нэг удаагийн буцалтгүй тусламж олгосугай.

2. Буцалтгүй тусламжид зарцуулах 420000 /дөрвөн зуун хорин мянга/ төгрөгийг зохих журмын дагуу гаргахыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс /Д.Долгорсүрэн/-т зөвшөөрсүгэй.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиглахыг Төрийн захиргааны удирдлагын газар /Д.Бат-Эрдэнэ/-т даалгасугай.

ДАРГА



Б. АСРАЛТ

1439501 4070